



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН
МОНИТОРИНГИЙН 301 ЦЭГТ ХИЙСЭН ХӨРСНИЙ ЭРҮҮЛ
АХУЙ, ХҮНД МЕТАЛЛЫН БОХИРДЛЫН
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Суурь судалгаа,
мониторингийн
хэлтэс

УЛААНБААТАР

2023 ОН

ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН 301 ЦЭГТ ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ, ХҮНД МЕТАЛЛЫН БОХИРДЛЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН


СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Нийслэлийн хот, тосгон бусад суурин газрын мониторингийн 301 цэгт хөрсний эрүүл ахуй, хүнд металлын бохирдлын судалгаа хийх, хөрсний эрүүл ахуй, бохирдлын дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэх, бохирдолд өртсөн газруудын байршлыг тодорхойлох, газрын мониторингийн системд сүлжээний цэгийг мэдээллээр баяжуулах, хөрс хамгаалах бохирдлыг бууруулах чиглэлээр санал боловсруулж тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахад ажлын зорилго оршино.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Налайх дүүргийн хот, тосгон бусад суурины газрын мониторингийн 301 цэгт хөрсний эрүүл ахуй, хүнд металлын бохирдлын судалгааг хийх, бохирдолд өртсөн байршлыг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зураг 1. Судалгааны талбайн байршил



Хүснэгт 1. Нийслэлийн 7 дүүргийн мониторингийн цэгийн тоо, байршил

№	Дүүрэг	Хороо	Мониторингийн цэгийн тоо
1	Сонгинохайрхан	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 20, 22, 23, 24, 26, 27, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 39, 40, 43 дугаар хороо	84
2	Хан-Уул	1, 3, 4, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 17, 19, 20, 21 дүгээр хороо	40
3	Баянгол	9, 10, 11, 13, 16, 20, 21, 22, 23 дугаар хороо	47
4	Сүхбаатар	1, 9, 11, 12, 13, 14, 16, 18 дугаар хороо	28
5	Чингэлтэй	5, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 15, 17, 19 дугаар хороо	25
6	Баянзүрх	2, 4, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 17, 19, 20, 21, 22, 23, 24, 26, 27, 28 дугаар хороо	65
7	Налайх	1, 2, 3, 4, 7, 8 дугаар хороо	12
НИЙТ ЦЭГ			301

СУДАЛГААНЫ АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА

2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Налайх дүүргийн хот, тосгон бусад суурины газрын мониторингийн 301 цэгт хээрийн хэмжилт, судалгааны ажлыг зохион байгуулж, хөрсний дээжүүдийг лабораторийн дүн шинжилгээгээр баталгаажуулсан.

Судалгааны ажилд ашигласан программ хангамж, багаж хэрэгсэл:

- Гар GPS;
- Судалгааны ажлын байршлын тойм зураг;
- Хөрсний бичиглэлийн маягт;
- Тор, гадас, хөрсний дээж авах уут, тэмдэглэх цаас, бал;
- Хүрз, метр, цагаан самбар, арилдаг болон арилдаггүй маркер;
- Фото зургийн аппарат;



СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ

Судалгааны ажлын үе шатууд

1. Хөрсний бохирдолын эх үүсвэрүүдийн тодруулга хийлээ (хатуу хог хаягдал, үйлдвэр аж ахуйн газрууд, урьд өмнө бохирдолд орсон газрууд г.м.)
2. Хөрсний бохирдолын цэгүүдийн фото зураг;
3. Нийслэлийн 7 дүүргийн нутаг дэвсгэрээс нийт 301 цэгээс хөрсний 301 ш дээж авсан;
4. Лабораторийн задлан шинжилгээ;
5. Дүн материал боловсруулалт, элементийн тархалтын цуврал зургууд.

Лабораторийн задлан шинжилгээ

Хөрсний дээжийг хатаах, шигших (2мм), задлан шинжилгээнд бэлдэх, “Дээж” хөрс

судлал, усны сорилтын лабораторид.

Хүнд металлууд (Cd, Pb, Zn, Ni, Cu, Cr), “Дээж” хөрс судлал, усны сорилтын лабораторид атомын шингээлтийн (AAC-атомын адсорбцын) спектрофотометрийн аргаар (Buck Scientific, 210 / 211VGP Atomic Absorption Spectrophotometers) тодорхойлсон.

Хөрсний эрүүл ахуй: Нянгийн тоо, гэдэсний бүлгийн савханцар г.м “Дээж” хөрс судлал, усны сорилтын лабораторид

Хөрсний дээж авах

- Хөрсний дээж авах.
- Дээж авах гүн: 0-5 см, 0-10 см, хөрсний үе давхаргаас

Хөрсний нянгийн бохирдлын судалгаа

Хөрсний нянгийн бохирдлын судалгааг дараахи 3 үзүүлэлтээр явуулсан. Үүнд:

1. 1 гр хөрсөнд агуулагдах нийт нянгийн тоо. Хөрсний дээжийг $1:10^1$ - $1:10^8$ хүртэл шингэрүүлэн HiMedia-ийн Nutrient Agar, Plate Count Agar тэжээлийн орчингуудыг савласан петрийн аяганд тарилга хийж 37 хэмд өсгөвөрлөн ургасан колоний тоог шингэрүүлгийн зэргээр үржүүлж 1 грамд агуулагдах нянгийн тоог гаргасан.

2. Гэдэсний бүлгийн савханцрын таньцийг тогтоохдоо исэлдүүлэх болон фильтрийн аргыг ашигласан. Исэлдүүлэх аргаар дээжний $1:10^1$ - $1:10^6$ хүртэлх шингэрүүлэг бүрээс HiMedia-ийн Lactose peptone broth, E.Coli broth шингэн тэжээлт орчингуудыг савласан хуруу шилнүүдэд 1 мл-ийг хийж өсгөвөрлөсөн бөгөөд 24 цагийн дараа хүчил, хий үүсгэн ургасан өсгөврөөс HiMedia-ийн Endo agar, Eosin Methylene Blue Agar-т батлах тарилга хийн, металлын гялалзсан улаан ягаан (Endo), хар өнгөтэй (EMB) колонуудаас HiMedia-ийн Oxidase disc-ийн тусламжтайгаар оксидазын сорил тавьж микроскопын үзлэг, граммын будагдалтаар гэдэсний савханцрын таньцыг тогтоосон.

3. Перфрингесийн

4. таньцийг тодорхойлох. Хөрсний дээжний $1:10^1$ - $1:10^6$ хүртэлх шингэрүүлэг бүрээс ариутгасан хуруу шилнүүдэд хийн 80 хэмд 15 минут халааж, ариун петрийн аяганд 1 мл дусааж дээрээс нь ариутган 45 хэм хүртэл хөргөсөн HiMedia-ийн Clostridial agar, Perfringens Agar Base тэжээлийн орчинг хийсэн. Улмаар тусгай саванд байрлуулан савны доторхи хүчилтөрөгчийг Mitsubishi Gas Chemical Co.,-ийн бүтээгдхүүнээр шингээн анаэроб орчинг бүрдүүлсэн. 37 хэмд 24 цаг өсгөвөрлөн орчинд ургасан хар өнгийн колоноос бэлдэц бэлтгэн микроскопын үзлэгээр Cl.perfringens-ийг тодорхойлсон.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Хүнд металлын бохирдол

Нийслэлийн 7 дүүргийн нутаг дэвсгэрийг хамруулан явуулсан хөрсний бохирдлын судалгаагаар байгалийн аясаараа байгаа буюу бохирдолтод өртөөгүй газар, хотын гудамж талбай, орон сууцны хороолол, гэр хороолол, шатахуун түгээх газрууд, худалдааны төвлөрсөн захууд, авто засварын газрууд зэрэг хог хаягдал янз бүрийн хэлбэрээр тархсан газруудаас хөрсний өнгөн үеийн нийт 301 ш дээж авч хөрсний химийн болон физикийн үндсэн шинжүүдийг “Дээж” хөрс судлалын лабораторид тодорхойлсон.

Лабораторийн задлан шинжилгээний дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Дүүрэг тус бүрээр хүнд металлын бохирдолтой цэгийн тоо

№	Дүүрэг	Хороо	Мониторингийн цэгийн тоо	Хүнд металлын бохирдолтой	Хүнд металлын бохирдолгүй
1	Сонгинохайрхан	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 20, 22, 23, 24, 26, 27, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 39, 40, 43 дугаар хороо	84	56	28
2	Хан-Уул	1, 3, 4, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 17, 19, 20, 21 дүгээр хороо	40	40	0
3	Баянгол	9, 10, 11, 13, 16, 20, 21, 22, 23 дугаар хороо	47	20	27
4	Сүхбаатар	1, 9, 11, 12, 13, 14, 16, 18 дугаар хороо	28	25	3
5	Чингэлтэй	5, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 15, 17, 19 дугаар хороо	25	22	3
6	Баянзүрх	2, 4, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 17, 19, 20, 21, 22, 23, 24, 26, 27, 28 дугаар хороо	65	57	8
7	Налайх	1, 2, 3, 4, 7, 8 дугаар хороо	12	12	0
НИЙТ ЦЭГ			301	232	69

Лабораторийн шинжилгээний хариунд дүн шинжилгээ хийхэд 7 дүүргийн хэмжээнд бохирдолгүй 69 цэг, хүнд металлын ямар нэгэн элементийн бохирдолтой 232 цэг байна.

Хүснэгт 3. Нийслэлийн дүүргүүдийн хүнд металлын агууламж, мг/кг

Дүүрэг		Pd	Ni	Cr	Cu	Cd	Zn
Сонгинохайрхан	max	118	33.9	128	46.3	47.9	189.6
	min	0.06	6.9	17.3	7.8	0.14	0.85
Сүхбаатар	max	74.6	48.5	32.8	42.5	4.7	157.6
	min	0.46	18.5	0.19	22.5	0.22	86.5
Баянзүрх	max	66.1	113.2	63.9	65.5	5.1	188.9

	min	0.2	8.7	1.96	14.4	0.14	51.1
Хан-Уул	max	32.03	45.2	13.5	65.2	5.56	139.6
	min	1.6	16.4	0.57	10.96	1.2	37.6
Чингэлтэй	max	39.7	38.46	94.36	52.86	6.29	168
	min	0.21	13.44	0.16	17.2	0.25	57.48
Баянгол	max	42.1	38.9	71.05	45.9	4.22	145.6
	min	23.7	13.7	12.2	13.02	0.7	40.2
Налайх	max	0	26.6	157.7	33.55	4.01	116.7
	min	0	10.91	35.42	10.42	1.05	31.7
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		50	60	60	60	1	100
Шавранцар хөрс		70	100	100	80	1.5	150
Шаварлаг хөрс		100	150	150	100	3	300

Хар тугалга (Pb)

Хар тугалга (Pb): ихэнх эрхтэн системийн тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлдэг, орчныг бохирдуулагч хортой бодис юм. Мэдрэлийн хор гэж нэрлэгддэг бөгөөд нөхөн үржихүйнтөгтолцоонд ч сөрөг нөлөө үзүүлэх, хүүхдийн өсөлтийг бууруулахаас гадна хүүхдийн тархины хөгжлийг саатуулах аюултайн зэрэгцээ оюуны хомсдолд хүргэж болох талтай. Ясны эдийн гэмтэл, цусан дахь уургийн нийлэгжилт саатах, мэдрэлийн систем, бөөр хямрах зэрэг сөрөг нөлөөтэй. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хүүхдийн цусанд агуулагдах хар тугалгын хэмжээг 5 мгр/дл гэж зааж өгсөн байдаг байна.

Дээжний шинжилгээний хариунд дүн шинжилгээ хийхэд 4 дүүргийн 25 цэгт хар тугалга (Pb)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна. Үүнд: Налайх, Баянгол, Хан-Уул дүүрэг хар тугалга (Pb)-ын бохирдолгүй, Чингэлтэй-1 /4%/, Сонгинохайрхан-15 /17,8%/, Баянзүрх-6 /9,2%/, Сүхбаатар-3 /10,7%/ цэгт хар тугалга (Pb)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна.

Хар тугалга (Pb)-ын хэмжээ 0.06-118 мг/кг-ын хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд Баянбүрд “Тосолгооны материал”-ын газар хамгийн өндөр үзүүлэлттэй, түүний дараагаар Эрдэнэтолгойн жалга, Баянхошууны 112-н аминыбайрны баруун жалга, Баянбүрд “Мэлтэс” авто засварын газар, Ногоон нуур орчим, Да хүрээ зэрэг газруудад өндөр үзүүлэлттэй байна.


Хүснэгт 4. Дүүргүүдийн хөрсөнд агуулагдах хар тугалга (Pb)-ын үзүүлэлтүүд

Дүүрэг	Хар тугалга (Pb)-ын агууламж, мг/кг	
	Их /max/	Бага /min/
Сонгинохайрхан	118	0.06
Сүхбаатар	74.6	0.46
Баянзүрх	66.1	0.2
Хан-Уул	32.03	1.6
Чингэлтэй	39.7	0.21


Баянгол	42.1	23.7
Налайх	0	0

Нийт судалгаанд хамрагдсан дээжний 9,05% нь стандартаас дээш бохирдолтой байна.

Зураг 2. Хөрсөн дэх хар тугалга (Pb)-ын бохирдолтой цэгийн байршил



Зураг 3. Хөрсөн дэх хар тугалга (Pb)-ын тархалтын зураг



Никель (Ni)



Никель (Ni) хортой хүнд металлын ангилалд хамаарагдах бөгөөд хүн, амьтан, ургамалын өсөлт хөгжилтэд сөрөг нөлөө үзүүлдэг, төрөл бүрийн өвчинн үүсгэх эх үүсвэр болдог. Никелийн гол хэрэглэ нь металл хайлшийн зэврэлтэд тэсвэртэй чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байдаг. Мөн шилэнд ногоон өнгө оруулах, цахилгааны утас, машины эд анги, зоосон мөнгө, батерей, төрөл бүрийн аккумулятор хийх зэрэгт түүхий эд нь болдог. Дээрх материалуудын элэгдэл хорогдол, төрөлжсөн үйлдвэрийн газраас эх сурвалжтай хот суурин газарт никелийн цэгэн болон талбайн бохирдол үүсдэг. Никель нь хөрсний үе давхаргад тодорхой агууламжтай байдаг. Харин хуримтлал нь үйлдвэр, хөдөө аж ахуйн идэвхтэй үйл ажиллагааны дүнд бий болдог. Энэхүү металл хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг нийтлэг тохиолдол нь харшил, тэр тусмаа арьсны төрөл бүрийн өвчлөл үүсгэх эх сурвалж нь болдог.

Дээжний шинжилгээний хариунд дүн шинжилгээ хийхэд 2 дүүргийн 12 цэгт никель (Ni)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна. Үүнд: Налайх, Баянгол, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт никель (Ni)-ын бохирдолгүй, Баянзүрх-11 /20,3%/, Сүхбаатар 1 /3,7%/ цэгт никель (Ni)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна.

Үр дүнгээс харахад Баянзүрх дүүргийн шар хад, Эрдэнэтолгой, Цайз, Сансарын тойргын замын хойд талын хэсэг, Сүхбаатар дүүргийн Дарь-Эх орчим бохирдолтой байна.

Нийт судалгаанд хамрагдсан дээжний 3,98% нь стандартаас дээш бохирдолтой байна.

Зураг 4. Хөрсөн дэх никель (Ni)-ын бохирдолтой цэгийн байршил



Зураг 5. Хөрсөн дэх никел (Ni)-ын тархалтын зураг

Хром (Cr)

Дээжний шинжилгээний хариунд дүн шинжилгээ хийхэд 5 дүүргийн 38 цэгт Хром (Cr)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой гарсан


байна. Үүнд: Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт Хром (Cr)-ын бохирдолгүй, Налайх-7 /28%/, Баянгол-3 /6,38%/, Чингэлтэй-5 /20%/, Сонгинохайрхан-18 /21,4%/, Баянзүрх-5 /7,69%/ цэгт Хром (Cr)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна.

Улаанбаатар хотын арьс шир боловсруулах үйлдвэрүүд хромтой химийн бодис хэрэглэснээс шалтгаалж хөрсөн дэх хромын агууламж нилээд өндөр буюу дунджаар 66 мг/кг байна.


Байршлаар нь үзвэл Баянгол дүүргийн Зурагт 20-р хороо үйлдвэрийн бүс, Баянзүрх дүүргийн Дарь-Эх, Шар хад, улиастай, Гачуурт, 16-р хороолол орчим, Чингэлтэй дүүргийн Дэнжийн мянга, “Хүчит Шонхор” худалдааны төв, Налайх дүүргийн төвийн хэсэг, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороо авто худалдааны төв болон төв цэвэрлэх байгууламж, эмээлтийн орчим мөн 1-р хороололын арын хэсэг орж байна.

Нийт судалгаанд хамрагдсан дээжний 14,4 % нь стандартаас дээш бохирдолтой байна.

Зураг 6. Хөрсөн дэх Хром (Cr)ын бохирдолтой цэгийн байршил



Зураг 7. Хөрсөн дэх Хром (Cr)-ын тархалтын зураг



Зэс (Cu)

Зэсийн илүүдэл нь эдийн органик өөрчлөлтүүд, ясны эдийн гэмтэл, элэгний үрэвсэл үүсгэнэ. Зэс болон бусад микро элементүүд нь хөрс үүсгэгч эх чулуулгийн эрдсийн найрлага, органик бодис, хөрсний уусмалд байх ба хөрсний хэв шинж, газар ашиглалтаас хамаарч харилцан адилгүй хэмжээтэй байдаг (С.Ичинхорлоо, 1990).


Дээжний шинжилгээний хариунд дүн шинжилгээ хийхэд 5 дүүргийн 4 цэгт Зэс (Cu)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой гарсан байна. Үүнд: Налайх, Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт Зэс (Cu)-ын бохирдолгүй, Хан-Уул-3 /7,5%/, Баянзүрх-1 /1,53%/ цэгт Зэс (Cu)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна.

Хөрсний зэсийн агууламж хамгийн их байгаа нь Баянбүрд “Тосолгооны материал”-ын газар бөгөөд Шувуун фабрик- 4-р хэсгийн дэлгүүрийн үүд, Эмээлт, Налайхын төв, Ар жанчивлан салаа, Толгойтын шинэ эцийн жалга, Эрдэнэтолгойн жалга, Зурагтын хуучин эцэс хогтой цэг, Бичил 6-р хорооллын далангийн баруун тал, Баянхошууны 112-н амины байрны баруун жалга, Далан давхрын гэр хорооллын дундах жалга, Улаанчулуут хогын цэг, Гэмтлийн эмнэлгийн хогийн цэг, Шувуун фабрик- 7-р хэсгийн айлуудын дундах хогын цэг, Ногоон нуурын доод тал, Хөлийн гол, Баянбүрд “Мэлтэс” авто засварын газар, Да хүрээ, Барс захын машины зогсоол зэрэг газар зэс өндөр агууламжтай байна.


Нийт судалгаанд хамрагдсан дээжний 1,34 % нь стандартаас дээш бохирдолтой

байна.

Зураг 8. Хөрсөн дэх Зэс (Cu)-ын бохирдолтой цэгийн байршил



Зураг 9. Хөрсөн дэх Зэс (Cu)-ын тархалтын зураг



Кадми (Kd)


Кадмий нь элэгний цироз, бөөрний үйл ажиллагааны дутагдал, протеинури үүсгэнэ. Кадмий нь батерей үйлдвэрлэдэг газарт металл мөнгөлж ашиглагддаг.

Дээжний шинжилгээний хариунд дүн шинжилгээ хийхэд 7 дүүргийн 206 цэгт Кадми (Cd)-ийн хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой гарсан байна. Үүнд: Налайх-12 /100%/, Баянгол-20 /42,5%/, Чингэлтэй-16 /64%/, Хан-Уул-40 /100%/, Сонгинохайрхан-44 /52,3%/, Баянзүрх-56 /86,1%/, Сүхбаатар 18 /64,2%/ цэгт Кадми (Cd)-ийн хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна.


Хөрсний кадми Улаанбаатар хотын Туул гол (Баянзүрхийн гүүр), Техникийн зах-Цахлайн тойрог, 100-н айл-худалдааны гудамж, Хархорин зах, Гандангийн зүүн жалга, Салхит, Баянбүрд “Солонгос авто засварын газар”, Баянбүрд “Тосолгооны материал” – ын газар зэрэгт өндөр агууламж байна.

Нийт судалгаанд хамрагдсан дээжний 68,4 % нь стандартаас дээш бохирдолтой байна.

Зураг 10. Хөрсөн дэх Кадми (Cd)-ын бохирдолтой цэгийн байршил



Зураг 11. Хөрсөн дэх Кадми (Cd)-ын тархалтын зураг



Цайр (Zn)


Дээжний шинжилгээний хариунд дүн шинжилгээ хийхэд 7 дүүргийн 89 цэгт Цайр (Zn)-ын хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой гарсан байна. Үүнд: Налайх-1 /8,3%, Баянгол-9 /19,1%, Чингэлтэй-12 /48%, Хан-Уул-15 /37,5%, Сонгинохайрхан-20 /23,8%, Баянзүрх-18 /27,6%, Сүхбаатар 14 /50% цэгт Цайр (Zn)-ийн хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн буюу бохирдолтой байна.

Нийт судалгаанд хамрагдсан дээжний 41,9 % нь стандартаас дээш бохирдолттой байна.


Зураг 12. Хөрсөн дэх Цайр (Zn)-ын бохирдолтой цэгийн байршил



НИЙСЛЭЛД ХИЙСЭН 300 ЦЭГИЙН БОХИРДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ЗУРАГ (Цайрын бохирдол)



Зураг 13. Хөрсөн дэх Цайр (Zn)-ын тархалтын зураг



ГАЗАР АШИГЛАЛТ


Улаанбаатар хотын нийт нутаг дэвсгэр нь 470 444 га болох бөгөөд үүнээс дүүрэг бүрээр тооцож үзэхэд: Хотоос алслагдсан дүүргүүд болох Бага нуур дүүрэг 62 020 га, Бага хангай дүүрэг 1400 га, нийслэлийн захын Налайх дүүрэг 68764 га, харин хотын төвийн дүүргүүдээс Баянгол дүүрэг 2429 га, Баянзүрх дүүрэг 124412 га, Сонгинохайрхан дүүрэг 120063 га, Сүхбаатар дүүрэг 20840 га, Хан-Уул дүүрэг 48466 га, Чингэлтэй дүүрэг 8930 га нутаг дэвсгэрийг тус тус эзэлнэ. Үүнээс 2021 оны эцэс

гэхэд нийт 231380.5 га талбайг хөдөө аж ахуйн газар, 74122.9 га талбай хот тосгон, бусад суурин газар, 5827.2 га зам, шугам сүлжээний газар, 73998.5 га ойн сан бүхий газар, 4078.2 га усан сан бүхий газар, харин үлдэх 72937.3 га талбай улсын тусгай хамлаалалттай газарт хамрагддаг байна.

Нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Баянгол, Налайх дүүргийн хот, тосгон бусад суурины газрын мониторингийн 301 цэгт хийсэн бохирдлын судалгааны үр дүнд бохирдлын шалтгааныг тодорхойлох зорилгоор хүнд металлын бохирдолтой цэг тус бүрт 200 метр радиус (buffer) татан иргэн, аж ахуй нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр олгогдсон газрын нэгж талбарын мэдээлэл болон газар ашиглалтын зориулалтыг дүүрэг тус бүрээр гаргасан байна. Үүнд:

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд нийт 84 цэгт бохирдлын судалгаа хийснээс 28 цэг хүнд металлын бохирдолгүй, 56 цэг зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан буюу бохирдолтой байна. Үүнээс 1 химийн элементээр бохирдсон 24 цэг, 2 болон түүнээс дээш химийн элементээр бохирдолтой 32 цэг байна.



Хүнд металлын бохирдолтой 56 цэгт 200 метр радиус (buffer) татан иргэн, аж ахуй нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр олгогдсон газрын нэгж талбарын мэдээлэл болон газар ашиглалтын зориулалтаар гаргахад дараах мэдээлэл харагдаж байна.

Хүснэгт 5. Сонгинохайрхан дүүргийн мониторингийн 84 цэгт хүнд металлын бохирдлын газар ашиглалтын мэдээлэл

№	Дээжний дугаар	Байршил	Газар ашиглалт /өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосон газрын зориулалтаар/	Нэгж талбарын тоо	Хүнд металлын бохирдол
1	1	Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-135 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1	136	Хар тугалга, Кадми, Цайр
2	2	Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-163	163	Кадми, Цайр
3	3	Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-146	146	Хром, Кадми, Цайр
4	4	Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороо	Амины орон сууц /2204/-1 Боловсролын байгууллага /2104/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-42 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-35 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар /2111/-1	80	Кадми, Цайр
5	5	Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо	Амины орон сууц /2204/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-216 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар /2111/-1	219	Хар тугалга, Кадми, Цайр
6	6	Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-182 Техникийн ургамлын усалгаатай тариалан /1304/-1	183	Кадми, Цайр
7	7	Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-185	185	Кадми, Цайр
8	8	Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-162 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар /2111/-1	163	Кадми, Цайр
9	9	Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-103 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар-1	104	Цайр
10	10	Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-69 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1	70	Хар тугалга, Кадми, Цайр
11	11	Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо	Амины орон сууц /2204/-1 Урлаг, соёлын байгууллага /2103/-1 Аж, ахуйн /7003/-1 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-165	168	Кадми, Цайр
12	12	Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар /2111/-2 Аж, ахуйн /7003/-1 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-186	189	Кадми, Цайр
13	13	Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо	Амины орон сууц /2204/-1 Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Аж, ахуйн /7003/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /3477/-1 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай /2601/-1 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-147	154	Хар тугалга, Кадми, Цайр
14	14	Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо	Амины орон сууц /2204/-1 Нам, олон нийтийн байгууллага /2108/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Дэд бүтцийн байгууллага /2112/-1 Боловсролын байгууллага /2104/-3 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-156	166	Кадми
15	15	Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-184 Амины орон сууц /2204/-1	185	Кадми
16	16	Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-165 Ус түгээх цэг /2118/-1	166	Кадми
17	17	Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-194 Ус түгээх цэг /2118/-2	196	Кадми


18	18	Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-200 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Боловсролын байгууллага /2104/-1 Аж ахуйн /7003/-1	205	Цайр
19	19	Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-166 Мөрөн, гол, горхи /5101/-1 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Боловсролын байгууллага /2104/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1	170	Кадми, Цайр
20	20	Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-194 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1	196	Кадми
21	21	Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-206 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /3477/-2 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1	209	Хар тугалга, Кадми
22	22	Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-226 Боловсролын байгууллага /2104/-1 Аж ахуйн /7003/-1 Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1	229	Хар тугалга, Кадми
23	23	Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-160 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Мод үржүүлгийн газар /4104/-1 Өвөл-хаврын бэлчээр /1101/-1 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1	165	Кадми
24	24	Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-174 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2	178	Хром, Кадми
25	25	Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-198	198	Хром, Кадми, Цайр
26	26	Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-144 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Аж ахуйн /7003/-1 Боловсролын байгууллага /2104/-3 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Ус түгээх цэг /2118/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-8 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1	163	Кадми, Цайр
27	27	Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-211 Амины орон сууц /2204/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-3	217	Хром, Кадми, Цайр
28	28	Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-227 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1	229	Хар тугалга
29	29	Сонгинохайрхан дүүрэг, 6-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-235 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1 Аж ахуйн /7003/-1 Боловсролын байгууллага /2104/-1	240	Хар тугалга
30	30	Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-138 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Өвөл-хаврын бэлчээр /1101/-1 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Амины орон сууц /2204/-5	146	Хар тугалга, Кадми

31	31	Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-102 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-2 Боловсролын байгууллага /2104/-1 Аж ахуйн /7003/-2 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-2	113	Хар тугалга, Кадми
32	32	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-3 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1 Автомашин гараж /2116/-1 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-5 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-9	23	Хром, Кадми
33	33	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-4 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-4 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-6	16	Хром, Кадми
34	34	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-4 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-8 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Үйлдвэрийн албан контор /2301/-1 Автотээврийн үйлчилгээний зориулалтын барилга, байгууламж /2119/-2 Автомашин засвар үйлчилгээний газар /4222/-1	19	Хар тугалга, Хром, Кадми
35	35	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-1 Цэвэрлэх байгууламж /3409/-2 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1	4	Хром, Кадми
36	36	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-6 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-16 Төрийн захиргааны байгууллага /2101/-1	24	Хром
37	37	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-6 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-2 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-18 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-3 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-9 Үйлчилгээний орон сууц /7004/-2 Боловсролын байгууллага /2104/-1 Ус түгээх, шахах, өргөх байгууламж /3406/-1	40	Кадми
38	38	Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо	Аж ахуйн /7003/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-4 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-2 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-8 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-61 Үйлчилгээний орон сууц /7004/-2	76	Хром
39	39	Сонгинохайрхан дүүрэг, 6-р хороо	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-16 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-2 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-3 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-110 Үйлчилгээний орон сууц /7004/-3 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Боловсролын байгууллага /2104/-1 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-4	140	Хар тугалга, Хром, Кадми

41	41	Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-35 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1 Автомашинны гараж /2116/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-3	42	Кадми
42	44	Сонгинохайрхан дүүрэг, 22-р хороо	Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-2 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-133	135	Кадми
43	46	Сонгинохайрхан дүүрэг, 23-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-38 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1	39	Хром, Кадми
44	47	Сонгинохайрхан дүүрэг, 23-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-200 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-2	202	Хром
45	52	Сонгинохайрхан дүүрэг, 26-р хороо	Биеийн тамир, спортын байгууллага /2107/-1 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-157	158	Кадми, Цайр
46	59	Сонгинохайрхан дүүрэг, 31-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-44	44	Хром
47	63	Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-80 ХАА-н үйлдвэрийн цогцолбор /1606/-1	81	Хар тугалга, Хром
48	65	Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо	Аж ахуйн /7003/-7 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-35 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1	43	Хар тугалга
49	67	Сонгинохайрхан дүүрэг, 8-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-11 Боловсролын байгууллага /2104/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1 Эрчим хүч дамжуулах станц /3402/-2	180	Кадми
50	68	Сонгинохайрхан дүүрэг, 9-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-130 Боловсролын байгууллага /2104/-1 Амины орон сууц /2204/-1 5-8 давхар нийтийн орон сууц /2201/-1	136	Кадми
51	69	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-3 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-4 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-6	14	Кадми
52	74	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-3 Хүлэмж, дарлага /1607/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-4 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-2 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1	11	Хром, Кадми
53	75	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-5 Мал эмнэлгийн үйлчилгээний цэг /1602/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2	9	Хром
54	76	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Аж ахуйн /7003/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-4 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-1 Автомашинны гараж /2116/-1 Цэвэрлэх байгууламж /3409/-1	8	Хром, Кадми
55	77	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо	Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Аж ахуйн /7003/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1	3	Хром, Кадми

СҮХБААТАР ДҮҮРЭГ

Сүхбаатар дүүргийн хэмжээнд нийт 28 цэгт бохирдлын судалгаа хийснээс 3 цэг хүнд металлын бохирдолгүй, 25 цэг зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан буюу бохирдолтой байна. Үүнээс 1 химийн элементээр бохирдсон 15 цэг, 2 химийн элементээр бохирдолтой 10 цэг байна.



Хүснэгт 6. Сүхбаатар дүүргийн мониторингийн 28 цэгт хүнд металлын бохирдлын газар ашиглалтын мэдээлэл

№	Дээжний дугаар	Байршил	Газар ашиглалт /өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосон газрын зориулалт/	Нэгж талбарын тоо	Хүнд металлын бохирдол
1	85	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо	Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-22 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1 Эрчим хүч дамжуулах станц /3402/-1 Шинжлэх ухааны байгууллага /2102/-1	28	Хар тугалга, Кадми
2	86	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3 Үйлчилгээний орон сууц /7004/-1	4	Хар тугалга, Кадми
3	87	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3	3	Хар тугалга, Кадми


4	88	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-12 Үйлчилгээний орон сууц /7004/-6 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-6 Гэр, орон сууцны хашааны газар /2205/-128 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-8 Боловсролын байгууллага /2104/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-2	166	Цайр
7	91	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-94 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-5 5-8 давхар нийтийн орон сууц /2201/-3 Төрийн захиргааны байгууллага /2101/-4 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-5 Үйлчилгээний орон сууц /7004/-7 Эрчим хүч дамжуулах станц /3402/-1	120	Цайр
8	92	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-88 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-2 Төрийн захиргааны байгууллага /2101/-3 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1 5-8 давхар нийтийн орон сууц /2201/-1 Боловсролын байгууллага /2104/-1	97	Цайр
9	93	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-170 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-7 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-3 Үйлчилгээний орон сууц /7004/-3 Аж ахуйн /7003/-1 Амины орон сууц /2204/-1	189	Цайр
11	95	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-130 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-6 5-8 давхар нийтийн орон сууц /2201/-6 Боловсролын байгууллага /2104/-1 Автомашинны гараж /2116/-1 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3	149	Кадми
12	96	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-96 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-7 Үйлчилгээний орон сууц /7004/-4 Төрийн захиргааны байгууллага /2101/-3 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-2 Аж ахуйн /7003/-3 Амины орон сууц /2204/-2	117	Кадми
13	97	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-122 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-11 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-7 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1 Эрүүл мэндийн байгууллага /2105/-3 Төрийн захиргааны байгууллага /2101/-3 Боловсролын байгууллага /2104/-2 Автомашинны гараж /2116/-2 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-4 5-8 давхар нийтийн орон сууц /2201/-1	157	Кадми, Цайр

14	98	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-91 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-26 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Боловсролын байгууллага /2104/-1 Амины орон сууц /2204/-1	124	Кадми
15	99	Сүхбаатар дүүрэг, 12-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-213 Амины орон сууц /2204/-2 Төрийн захиргааны байгууллага /2101/-3 Боловсролын байгууллага /2104/-1	219	Кадми, Цайр
16	100	Сүхбаатар дүүрэг, 12-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-177 Амины орон сууц /2204/-1 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-2 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3 ХАА-н үйлдвэрийн цогцолбор /1606/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Аж ахуйн /7003/-3	188	Кадми, Цайр
17	101	Сүхбаатар дүүрэг, 12-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-211 Амины орон сууц /2204/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-3 Аж ахуйн /7003/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-2 Боловсролын байгууллага /2104/-1	219	Кадми, Цайр
18	102	Сүхбаатар дүүрэг, 12-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-228 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-4 Үйлдвэрийн албан контор /2301/-1	235	Никель, Кадми
19	103	Сүхбаатар дүүрэг, 12-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-251 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1 Үйлдвэрийн албан контор /2301/-1 4 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2203/-2 Амины орон сууц /2204/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1	258	Кадми, Цайр
21	105	Сүхбаатар дүүрэг, 13-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-72 Мод үржүүлгийн газар /4104/-1 Ус түгээх цэг /2118/-1	74	Кадми
22	106	Сүхбаатар дүүрэг, 13-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-97 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1	98	Кадми
23	107	Сүхбаатар дүүрэг, 13-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-152 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1	153	Кадми
24	108	Сүхбаатар дүүрэг, 13-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-143 Амины орон сууц /2204/-1 Нам, олон нийтийн байгууллага /2108/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Аж ахуйн /7003/-1 Боловсролын байгууллага /2104/-2 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-8 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1	160	Кадми
25	109	Сүхбаатар дүүрэг, 14-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-160 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-6 Боловсролын байгууллага /2104/-2 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1	174	Цайр

26	110	Сүхбаатар дүүрэг, 16-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-57 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Мод үржүүлгийн газар /4104/-1 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-1 Боловсролын байгууллага /2104/-1	61	Кадми, Цайр
27	111	Сүхбаатар дүүрэг, 18-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-51 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-6	57	Цайр
28	112	Сүхбаатар дүүрэг, 18-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-135 Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар /2206/-17 Аж ахуйн /7003/-1	153	Цайр

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Баянзүрх дүүргийн хэмжээнд нийт 65 цэгт бохирдлын судалгаа хийснээс 7 цэгт хүнд металлын бохирдолгүй, 58 цэгт зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан буюу бохирдолтой гарсан байна. Үүнээс 1 химийн элементээр бохирдсон 33 цэг, 2 болон түүнээс дээш химийн элементээр бохирдолтой 25 цэг байна.



Хүснэгт 7. Баянзүрх дүүргийн мониторингийн 65 цэгт хүнд металлын бохирдлын газар ашиглалтын мэдээлэл

№	Дээжний дугаар	Байршил	Газар ашиглалт /өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосон газрын зориулалт/	Нэгж талбарын тоо	Хүнд металлын бохирдол
1	113	Баянзүрх дүүрэг, 20-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-110 Амины орон сууц /2204/-1 Холбоо, мэдээлэл хүлээн авах станц /3401/-2	113	
2	114	Баянзүрх дүүрэг, 23-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-159 Амины орон сууц /2204/-2	161	
3	115	Баянзүрх дүүрэг, 9-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-153 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 4 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2203/-1 ХАА-н үйлдвэрийн цогцолбор /1606/-2	158	Кадми
5	117	Баянзүрх дүүрэг, 9-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-102 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 4 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2203/-2 ХАА-н үйлдвэрийн цогцолбор /1606/-2 Ус түгээх цэг /2118/-1 Төмс, хүнсний ногооны усалгааны тариалан /1302/-1	108	Кадми
7	119	Баянзүрх дүүрэг, 24-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-129 Төрийн захиргааны байгууллага /2101/-1	130	Кадми, Цайр

8	120	Баянзүрх дүүрэг, 19-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-164 Амины орон сууц /2204/-2	166	Кадми
9	121	Баянзүрх дүүрэг, 27-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-208 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1	211	Кадми, Цайр
10	122	Баянзүрх дүүрэг, 27-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-217	217	Кадми
11	123	Баянзүрх дүүрэг, 21-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-70 Амины орон сууц /2204/-2	72	Кадми
12	124	Баянзүрх дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-190	190	Кадми
13	125	Баянзүрх дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-176	176	Кадми
14	126	Баянзүрх дүүрэг, 8-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-131 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-10 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-1 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1 Боловсролын байгууллага /2104/-1	149	Кадми, Цайр
15	127	Баянзүрх дүүрэг, 8-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-70 Төрийн захиргааны байгууллага /2101/-4 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-10 Үйлчилгээний орон сууц /7004/-2 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-2	93	Зэс, Кадми, Цайр
17	129	Баянзүрх дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-120 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-4 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 5-8 давхар нийтийн орон сууц /2202/-3 ХАА-н үйлдвэрийн цогцолбор /1606/-1 Боловсролын байгууллага /2104/-1 Авто замын сургалт, дадлагын талбай /3206/-1	135	Кадми
18	130	Баянзүрх дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-143 5-8 давхар нийтийн орон сууц /2202/-2	145	Кадми
19	131	Баянзүрх дүүрэг, 8-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-104 4 ба түүнээс давхар нийтийн орон сууц /2203/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Аж ахуйн /7003/-3 Боловсролын байгууллага /2104/-3 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-4 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1	120	Кадми, Цайр
20	132	Баянзүрх дүүрэг, 24-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-94 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-15 Үйлчилгээний орон сууц /7004/-2 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-2 Амины орон сууц /2204/-1 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1 4 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2203/-1 Автомашин засвар, үйлчилгээний газар /2115/-1	117	Кадми
23	135	Баянзүрх дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-210 Аж ахуйн /7003/-2 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-1	215	Кадми

24	136	Баянзүрх дүүрэг, 8-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-104 4 ба түүнээс давхар нийтийн орон сууц /2203/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Аж ахуйн /7003/-3 Боловсролын байгууллага /2104/-3 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-4 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1	120	Кадми
25	137	Баянзүрх дүүрэг, 8-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-157 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3 Дэд бүтцийн байгууллага /2112/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Амины орон сууц /2204/-2	166	Кадми
26	138	Баянзүрх дүүрэг, 8-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-180 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1	181	Кадми
27	139	Баянзүрх дүүрэг, 2-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-73 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-15 Амины орон сууц /2204/-11 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-4 Үйлчилгээний орон сууц /7004/-5 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-2 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1 Боловсролын байгууллага /2104/-1 Автомашинны гараж /2116/-1 Үйлдвэрийн албан контор /2301/-1 Ус түгээх, шахах, өргөх байгууламж /3406/-1	145	Никель
28	140	Баянзүрх дүүрэг, 5-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-178 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-4 Үйлчилгээний орон сууц /7004/-1 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-2 Автотээврийн үйлчилгээний зориулалтын барилга, байгууламж /2119/-1 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1	186	Никель, Хром, Кадми
29	141	Баянзүрх дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-134 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Холбоо, мэдээлэл хүлээн авах станц /3401/-1	136	Никель, Кадми, Цайр
30	142	Баянзүрх дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-188 Дэд бүтцийн байгууллага /2112/-1	189	Никель, Цайр
31	143	Баянзүрх дүүрэг, 4-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-163	163	Никель, Хром, Кадми, Цайр
32	144	Баянзүрх дүүрэг, 22-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-176 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Үйлчилгээний орон сууц /7004/-5 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2	187	Хар тугалга, Никель, Кадми
33	145	Баянзүрх дүүрэг, 22-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-151 Эрүүл мэндийн байгууллага /2105/-1	152	Хар тугалга, Никель, Кадми
34	146	Баянзүрх дүүрэг, 19-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-42 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-6 Үйлчилгээний орон сууц /7004/-6 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-2 Төрийн захиргааны байгууллага /2101/-1 Аж ахуйн /7003/-3 Амины орон сууц /2204/-4 Шатах, тослох материал түгээгүүрийн газар агуулах, ШТС /2117/-1	65	Никель, Кадми


35	147	Баянзүрх дүүрэг, 19-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-88 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-13 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Төрийн захиргааны байгууллага /2101/-2 Аж ахуйн /7003/-3 Амины орон сууц /2204/-1 Боловсролын байгууллага /2104/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-6 ХАА-н үйлдвэрийн цогцолбор /1606/-6	116	Никель, Кадми
36	148	Баянзүрх дүүрэг, 24-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-202 Үр тарианы усалгаатай тариалан /1301/-1 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3 Аж ахуйн /7003/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-1	210	Никель, Хром, Кадми
37	149	Баянзүрх дүүрэг, 17-р хороо	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-161 Аж ахуйн /7003/-1 Цэвэрлэх байгууламж /3409/-1	163	Никель, Кадми
<i>Баянзүрх дүүргийн 1 дүгээр албаны мониторингийн цэгт хүнд металлын бохирдлын газар ашиглалтын мэдээлэл</i>					
1	150	Баянзүрх дүүрэг	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /2201/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-2 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, ОУ-ийн байгууллага /6401/-1	7	Кадми
2	151	Баянзүрх дүүрэг	Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1	1	Хар тугалга, Кадми
3	152	Баянзүрх дүүрэг	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-71 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-6 5-8 давхар нийтийн орон сууц /2202/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-9	91	Кадми
4	153	Баянзүрх дүүрэг	Эрчим хүч дамжуулах станц /3402/-1 Нийтийн эзэмшлийн бусад газар /2409/-1 Дэд бүтцийн байгууллага /2112/-1		Кадми
5	154	Баянзүрх дүүрэг	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-191 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-3 Үйлчилгээний орон сууц /7004/-2	196	Кадми, Цайр
6	155	Баянзүрх дүүрэг	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-138 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-1 Үйлчилгээний орон сууц /7004/-1 Сүм, хийд, шашны байгууллага /2109/-1 Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар /2302/-2	143	Кадми, Цайр
7	156	Баянзүрх дүүрэг	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-49 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-17 Үйлчилгээний орон сууц /7004/-4	70	Кадми
8	157	Баянзүрх дүүрэг	Гэр, орон сууцны хашааны газар /2205/-146 Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /2111/-2 Үйлчилгээний орон сууц /7004/-1 4 ба түүнээс давхар нийтийн орон сууц /2203/-4 Амины орон сууц /2204/-13	166	Хар тугалга, Кадми, Цайр
